МАРКШЕЙДЕРИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮРЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЗААВАР, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1.Энэхүү заавар, шаардлагын зорилго нь Ашигт малтмалын тухай хуулийн 29^1, 29^2 дугаар зүйлд заасан маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа явуулах заавар, тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, хүчингүй болгоход тавигдах шаардлагыг тогтооход оршино.

1.2.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хэрэглэх техникийн арга, аргачлал, стандарт, хэмжилтийн нарийвчлал болон бусад техникийн шаардлагыг холбогдох хууль тогтоомж, стандарт, техникийн зааврааар зохицуулна.

1.3.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагаандаа холбогдох дүрэм, журам, стандартыг чанд мөрдөж, мэргэжлийн хараат бус байдлыг эрхэмлэж, гаргасан дүгнэлтийн үнэн бодит, найдвартай байдлыг хариуцаж, аюулгүй байдлыг нэн тэргүүнд баримтлаж, ордын нөөцийг бүрэн ашиглахад шаардлагатай зөвлөмж, дүгнэлтийг боловсруулж, мэргэжлийн ёс зүйн хэм, хэмжээг сахиж, авлига, ашиг сонирхлоос ангид байж, бусад инженерийн мэргэжлийн чиг үүргийг хүндэтгэх зарчмыг баримтална.

1.4.Энэхүү заавар, шаардлагад хэрэглэсэн нэр томьёог Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан утгаар ойлгоно.

Хоёр. Маркшейдерийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.1. Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

2.1.1.ордын нөөцийг бүрэн, зохистой олборлож буй эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах, нөөцийн хөдөлгөөнийг тодорхойлох;

2.1.2.уулын ажлын гүйцэтгэл, хөрс хуулалт, хүдэр олборлолт, далд уурхайн малталт, түүний хэмжээсүүдийг тодорхойлох, хэмжиж, баталгаажуулах, хүдэр, хөрс, хаягдлын овоолгын хэмжээг тодорхойлох, уулын ажилд хамрагдсан, эвдэрсэн талбайн хэмжээг тооцоолох, уулын ажлын тайланд хөндлөнгийн дүгнэлт гаргах, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох олборлолт, борлуулалтын тоо хэмжээг баталгаажуулахад дүгнэлт гаргах;

2.1.3.техник, эдийн засгийн үндэслэлд тухайн жилийн төлөвлөлтийн нийцлийг хянах, ил болон далд уурхайн төлөвлөлтөд хөндлөнгийн дүгнэлт гаргах;

2.1.4.уурхайн хажуу болон хаягдал чулуулгийн овоолго, баяжуулах үйлдвэрийн хаягдлын сангийн тогтворжилтын байдал, чулуулгийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах;

2.1.5.тусгай зөвшөөрлийн талбайн хилийг тогтоож, шав тэмдэг тавих ажлыг гүйцэтгэх;

2.1.6.уурхай, баяжуулах үйлдвэрийг хүлээн авах комисст маркшейдерийн дүгнэлт өгөх, уурхайн хаалт, түүний тодотголд дүгнэлт гаргах, уурхайн хаалтад маркшейдерийн баримт бичгийг бүрдүүлэх;

2.1.7.газрын хэвлийг ашиглахтай холбогдуулан уулын малталтууд, барилга байгууламж, байгалийн объектуудыг хамгаалах арга хэмжээг боловсруулж, аюулгүйн бүсийг тодорхойлох.

Гурав. Маркшейдерийн тусгай зөвшөөрлийг олгоход тавигдах шаардлага, сунгах, хүчингүй болгох

3.1.Маркейдерийн тусгай зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.1.1.Монгол Улсын иргэн байх;

3.1.2.маркшейдер мэргэжлээр баклаврын боловсрол эзэмшсэн байх;

3.1.3.ил болон далд уурхайд 8-аас дээш жил ажилласан туршлагатай байх;

3.1.4.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг мэргэжлийн, өндөр түвшинд гүйцэтгэх дадлага, туршлага, мэргэжлийн чадамжтай байх;

3.1.5.маркшейдерийн үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомж, уурхайн аюулгүй ажиллагаа, мэргэжлийн хариуцлага, хэмжилт, зураглалын үндсэн шаардлагын талаар мэдлэгтэй байх;

3.1.6.ял шийтгэлгүй байх.

3.2.Тусгай зөвшөөрөл хүсэгч нь энэхүү заавар, шаардлагын 3.1-д заасан шаардлагыг ханган тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

3.3.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.2, 5.3-д заасныг баримтлан ажиллана.

3.4.Маркшейдерийн тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар сунгаж болно.

3.5.Маркшейдерийн тусгай зөвшөөрлийг сунгах өргөдлийг Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 2-д заасан хугацаанд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргах бөгөөд дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

3.5.1.тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд мэргэжлийн болон ёс зүйн хариуцлага хүлээгээгүй байх;

3.5.2.тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд хэрхэн ажилласан талаарх тодорхойлолтыг мэргэжлийн холбооноос авсан байх;

3.5.3.тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагааны тайлан.

3.6. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1-д заасан нөхцөл, шаардлага тогтоогдсон, эсхүл энэхүү заавар, шаардлагын 6-д заасан хориглосон үйл

ажиллагааг явуулсан гэж үзвэл Маркшейдерийн тусгай зөвшөөрлийг 3 хүртэлх сараар түдгэлзүүлнэ.

3.7. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1-д заасан нөхцөл үүссэн гэж үзвэл Маркшейдерийн тусгай зөвшөөрлийг мөн хуулийн 6.3 дугаар зүйлд заасны дагуу хүчингүй болгоно.

Дөрөв. Маркшейдерийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага

4.1.Маркшейдерийн ажил нь газрын хэвлийг хамгаалах, зөв ашиглах, уулын ажлыг аюулгүй явуулахад шаардагдах хэмжилтийн зохих нарийвчлалыг хангасан байна.

4.2.Газрын гадаргуу дээрх обьектууд, газар дорхи уулын малтадтуудын зураглалыг солбицлын нэг системд үйлдэж, уул-геометрийн график зургууд болон бичиг баримтыг бүрдүүлсэн байна. / уул уурхайн график зураг, MNS 6302-1:2011 - MNS 6302-8:2011 стандарт/

4.3.Маркшейдерийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд дараах шаардлагыг баримтлан ажиллана. Үүнд:

4.3.1.ил уурхайн хувьд уулын ажлын ахилт, олборлолтын хил, хөрс хуулалт, овоолго, ажлын талбайн өөрчлөлтийг тогтмол хэмжиж баримтжуулах;

4.3.2.далд уурхайн хувьд малталтын байршил, чиглэл, огтлол, ахилт, олборлолтын хэсэг болон аюулгүй ажиллагаанд шаардлагатай маркшейдерийн мэдээллийг бүрдүүлэх;

4.3.3.ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөн, олборлолтын хэмжээг тодорхойлохдоо ордын батлагдсан нөөц, олборлосон ашигт малтмалын хэмжээ, хаягдал, бохирдол, үлдэгдэл нөөцийн хэмжээтэй уялдуулах ба олборлолтын хэмжээг маркшейдерийн хэмжилт, уурхайн бүртгэл, холбогдох анхдагч баримтад үндэслэн тооцох;

4.3.4.нөөцийн хөдөлгөөний мэдээлэлд зөрүү илэрсэн тохиолдолд шалтгааныг тодорхойлж, дүгнэлтэд тусгах;

4.3.5.хаягдал чулуулгийн болон бусад овоолгын хэмжээг тогтоосон давтамжаар хэмжиж, эзэлхүүн болон талбайн өөрчлөлтийг тодорхойлох;

4.3.6.уурхайн хажуу болон овоолгын шилжилт, суулт, хэв гажилтыг шаардлагатай тохиолдолд мониторингийн аргаар хянах ба аюултай өөрчлөлт илэрсэн тохиолдолд холбогдох албан тушаалтанд шуурхай мэдэгдэж, эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаар санал гаргах;

4.3.7.хөндлөнгийн дүгнэлтийг бодит хэмжилт, анхдагч мэдээлэл, холбогдох баримт бичигт үндэслэн хийх.

4.4.Хэмжилтийн анхдагч мэдээлэл болон багажны мэдээлэл, боловсруулалтын үр дүн баримтжуулах ба хэмжилтийн мэдээллийг давтан шалгах, алдааг илрүүлэх боломжтой байдлаар хадгална.

4.5.Маркшейдерийн хэмжилтийн багажийг геодезийн хэмжил зүйн лабораториар баталгаажуулсан байна.

4.6.Гаднын байгууллага, өмнөх гүйцэтгэгч болон бусад эх үүсвэрээс авсан хэмжилт, зураглал, өгөгдлийг мэргэжлийн баримт бичигт ашиглахын өмнө түүний гарал үүсэл, нийцэл, бодитой байдлыг боломжит хэмжээнд шалгаж, эх сурвалжийг заавал тэмдэглэнэ.

4.7.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэргэжлийн удирдлага, хяналтын дор маркшейдер, инженер, техникч, хэмжилтийн ажилтан, тоног төхөөрөмжийн оператор болон зохих чадвартай бусад ажилтан маркшейдерийн өдөр тутмын хэмжилт, өгөгдөл цуглуулах, боловсруулах, зураг шинэчлэх ажлыг гүйцэтгэж болно.

4.8.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дүгнэлт гаргахдаа аливаа этгээдийн хууль бус нөлөөллөөс ангид байна.

4.9.Өөрийн хамаарал бүхий этгээдийн шууд ашиг сонирхолтой ажилд хөндлөнгийн дүгнэлт гаргахгүй байх бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүссэн бол холбогдох этгээдэд мэдэгдэнэ.

Тав. Маркшейдерийн ажлын гүйцэтгэл, баталгаажуулалт

5.1.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү заавар, шаардлагын 2-т заасан аливаа ажлуудыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж, холбогдох баримт бичигт гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

5.2.Энэхүү заавар, шаардлагын 4.7-д заасан ажил нь мэргэжлийн хариуцлага бүхий эцсийн тайлан, зураг, тооцоо, дүгнэлтийн бүрэлдэхүүн болсон тохиолдолд маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн ажлын эх өгөгдөл, боловсруулалт, чанарын хяналтыг шалгаж, баталгаажуулна.

5.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрөө гүйцэтгээгүй боловч өөрийн зохих мэргэжлийн хяналтын дор гүйцэтгэсэн ажлыг шалгаж, баталгаажуулж болно.

5.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрөө гүйцэтгээгүй боловч өөрийн зохих мэргэжлийн хяналтын дор гүйцэтгэсэн ажлыг шалгаж, баталгаажуулж болно.

5.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн хяналтад байгаагүй, эх өгөгдөл болон боловсруулалтыг шалгах боломжгүй, үнэн зөв байдалд нь эргэлзээтэй ажлыг баталгаажуулахгүй байх эрхтэй.

Зургаа. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд хориглох зүйл

6.1. Маркшейдерийн тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:

6.1.1.маркшейдерийн тусгай зөвшөөрлийн хүрээнд өөрийн боловсруулсан төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, уулын ажлын тайлан, төлөвлөгөөнд хөндлөнгийн дүгнэлт гаргах;

6.1.2.нэг төсөл хэрэгжүүлэгчид 3 жил дараалан дүгнэлт гаргах;

6.1.3.баталгаажуулаагүй хэмжилтийн багаж хэрэгслийг хэмжилт, зураглалын ажилд дүгнэлт гаргах;

6.1.4.өөрийн хамаарал бүхий этгээдийн төсөлд дүгнэлт гаргах.

Долоо. Маркшейдерийн үйл ажиллагааны зардал, гэрээ

7.1.Энэхүү заавар, шаардлагын 2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг төсөл хэрэгжүүлэгчээс гэрээний үндсэн дээр гаргуулж болно.

7.2.Гэрээнд ажлын цар хүрээ, гүйцэтгэх хугацаа, хүлээлгэн өгөх баримт бичиг, зардал, төлбөрийн нөхцөл болон талуудын эрх, үүргийг тодорхой тусгана.

7.3.Гэрээний төлбөрийн нөхцөл маркшейдерийн хараат бус дүгнэлт гаргах зарчимд нөлөөлөхгүй байна.

Найм. Хариуцлага, хяналт

8.1.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү зааврын 2-т заасан ажлын үнэн бодит байдлыг хариуцах ба баталгаажуулсан бүхий л ажилд эцсийн мэргэжлийн хариуцлага хүлээнэ.

8.2.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь маркшейдерийн бүх хэмжилт, зураглал, өгөгдөл боловсруулах ажлыг биечлэн гүйцэтгэх үүрэг хүлээхгүй.

8.3.Маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хуудь тогтоомжид заасан эрх бүхий байгууллага хяналт тавина.

8.4.Эрх бүхий байгууллага шаардсан тохиолдолд маркшейдерийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэмжилтийн анхдагч материал, тооцоо, зураг, дүгнэлт болон холбогдох баримтыг гаргаж өгнө.

8.5.Худал мэдээлэл, хуурамч баримт ашигласан, хэмжилт болон дүгнэлтийг санаатайгаар буруу гаргасан, эсхүл хууль тогтоомж зөрчсөн бол Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлд зааснаас гадна холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

Долоо. Бусад зохицуулалт

9.1.Энэхүү заавар, шаардлагад тусгайлан зохицуулаагүй асуудлыг Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

9.2.Энэхүү заавар, шаардлагыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.